

БАТЛАВ

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Ж.ЧИНБҮРЭН

**ЭМИЙН ХЯНАЛТЫН ТҮР ХОРОО БАЙГУУЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг. Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах
үндэслэл, шаардлага**

Монгол Улсад эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, түгээх, хэрэглэх, хянах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг 2010 оны 5 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулиар зохицуулж ирсэн бөгөөд 6 удаагийн нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Эрүүл мэндийн яам болон Азийн хөгжлийн банкны санаачлагаар 2017 онд “Монгол улсын эмийн үнэ, хүртээмж, худалдан авах боломж, үнэ бүрдлийн судалгаа”-г Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон Олон улсын эрүүл мэндийн үйл ажиллагааны байгууллагын стандарт аргачлалын дагуу хийж гүйцэтгэжээ.

Судалгааны дүнд хамгийн хямд үнэтэй ерөнхий нэршлийн эмийн хүртээмж хангалтгүй байх ба улсын байгууллагын хангамж 53.6%, хувийн хэвшлийн байгууллагын хангамж 68.9%, эмийн эргэлтийн сангийн хангамж 51.2% байна. Үүнээс үзэхэд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан зөвлөмжийн дагуу зайлшгүй шаардлагатай эмийг 80 хувийн хүртээмжтэй байлгах зорилгод хүрэхгүй байна. Иймд цаашид эмийн хүртээмжийн хангалтгүй байдлын шалтгаан нөхцөлийг нарийвчлан судлах шаардлагатай байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжөөр стандарт эмчилгээнд нэгээс илүүгүй өдрийн цалин зарцуулагдаж буй тохиолдолд эдийн засгийн дарамтгүй гэж үздэг. Монгол улсад халдварт бус өвчний 30 өдрийн эмчилгээ, халдварт өвчний 7 өдрийн эмчилгээнд зарцуулагдах өртөгийг хамгийн хямд үнэтэй ерөнхий нэршлийн эмээр тооцоолжээ. Гэтэл 12 долоо хоногийн курс эмчилгээнд шаардагдах офосбувир/ледипасвир шахмал дундаж цалинтай ажилтны 93 өдрийн цалинтай тэнцэж байна.

Мөн “Хүний эмийн чанар, хуурамч болон стандарт бус эмийн үйлдвэрлэл, нийлүүлэлтийн асуудлаар” хянан шалгах түр хорооноос “хүний эмийн чанар, стандартыг шалгах явцад эмийн үнийн асуудлыг нарийвчлан судлах, зах зээл дээр худалдаалагдаж байгаа болон Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн үнийн өсөлтийн бодит шалтгаан нөхцөлийн

харилцан уялдаатайгаар хяналт шалгалтыг цаашид үргэлжүүлэн хийх шаардлагатай” гэсэн дүгнэлтийн дагуу цаашид эмийн үнийн өсөлтийн шалтгаан нөхцөлийг хянан шалгах шаардлагатай байгаа юм.

Түүнчлэн зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг батлах журам, жагсаалт батлахтай холбоотой тулгамдаж буй асуудлыг тодорхойлон үе шаттайгаар судлах шаардлага тулгарч байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасныг үндэслэн эмийн үнийн өсөлтийн шалтгаан нөхцөлийг хянан шалгах асуудлаар шалгалт хийн дүнг нэгдсэн чуулганд танилцуулах, шаардлагатай бол санал боловсруулах үүрэг бүхий хянан шалгах түр хороог байгуулах тогтоолын төслийг боловсрууллаа.

Хоёр. Тогтоолын төслийн бүтэц, агуулга

Тогтоолын төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хуульд заасан үндэслэл, шалгуурын дагуу боловсруулагдсан бөгөөд төсөлд хяналт шалгалтын түр хорооны чиг үүрэг, хяналт шалгалтын хүрээ, хяналтын шалгалтын хамрах хугацааг тусгасан.

Түр хороо нь хяналт шалгалтын үйл ажиллагааг тогтоол хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш 6 сарын хугацаанд гүйцэтгэхээр тогтоолын төсөлд тусгасан.

Гурав.Тогтоолын төсөл нь бусад хууль тогтоомжтой хэрхэн уялдах, уг тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн талаар

Энэхүү тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой бүрэн нийцэж байгаа болно. Тогтоолын төсөлтэй холбогдуулан бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.